

Эрүүл мэндийн сайдын 2023 оны . . .
дугаар сарын ... - ны өдрийн . . .
дугаар тушаалын хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох
тэргүүлэх чиглэл
(2023-2026 он)**

Нэг. Нийтлэг зүйл

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид "Тусгай зөвшөөрөл" гэх) хүсэгчийн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэр гаргахад энэхүү чиглэлийг баримталж удирдлага болгоно.

2.Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл нь Зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуультай тус тус нийцсэн байна.

3.Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон салбарын хүний нөөцийн хөгжлийн тогтолцоонд олон улсын стандарт, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд тэргүүн ээлжинд үндэсний хөрөнгө оруулалт, улмаар манай оронд эмчлэх боломжгүй тусламж, үйлчилгээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зарчим баримтална.

4.Энэхүү тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын тоо, газар зүйн байршил, онцлог, эрүүл мэндийн үзүүлэлтийг үндэслэн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой бүрдлийг бий болгоход дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

4.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;

4.2 Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулах;

4.3 Тусламж, үйлчилгээний давхардлыг арилгаж, ачаалал хуваалцахад чиглүүлэх;

4.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчилгээ, бүтээгдэхүүний үнийг бууруулах өрсөлдөөнийг дэмжих.

5.Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд тус хуулийн 19.5.1-д заасан тохиолдолд олгоно.

6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх тусгай зөвшөөрлийн ажлын алба хүн амын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг 3 жил тутамд үнэлэн, үнэлгээний дүнг,

дараагийн баримтлах тэргүүлэх чиглэлийн саналын хамт 12 дугаар сарын 01 -ний дотор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисст ирүүлнэ

7.Энэхүү тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллагууд Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад цахим болон цаасан хэлбэрээр хүсэлтээ гаргана.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.6-13.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн чиглэлийн хүрээнд 2023-2026 онд баримтлах тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг дор дурдсанаар тогтоож байна. Үүнд:

2.1.Сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ:

2.2.Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ:

2.3.Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:

2.1.3.1.хот, суурин газрын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ.

2.4.Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ

2.5.Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх:

2.5.1Импорт орлох эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл;

2.5.2.Эмийн үйлдвэр өөрийн үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд, туслах бодис импортлох.

2.6.Эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах:

2.3.1.Эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай газар нутгийн хүн амд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа.

2.7.Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх импортлох, ханган нийлүүлэх, түүний засвар үйлчилгээ эрхлэх:

2.8.Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх:

2.9.Тухайн орон нутгийн засаг захиргаанаас Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудлыг шийдэж чадаагүй алслагдсан байршилд байрлан, хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн тусламж үйлчилгээг дэмжинэ.